Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, түүнд тавих хяналтыг өндөржүүлэх, бүртгэл тооцоог байгууллага бүрээр хөтлөн өмчийн үр ашгийг дээшлүүлэх, худалдан авах ажиллагааны шалгаруулалтыг ил тод, шударга болгож хуваарилагдсан төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр дүнтэй ашиглаж, өрсөлдөх тэгш боломж олгох, хариуцлагатай байх нөхцөлийг хангаж ажиллаж байна.

## 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, зэрэг нь байгууллагын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 388 дугаар "Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 488 тоот "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаал "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам";
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай";
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол "Автомашин ашиглалтын тухай".

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус онд байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй.

## 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,621.6 мянган төгрөгөөр буюу 4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 1,005.0 | 1,046.3 | 41.4 |
| Бараа материал | 5,326.0 | 5,394.7 | 68.7 |
| Үндсэн хөрөнгө | 34,275.1 | 35,786.6 | 1,511.5 |
| **Нийт хөрөнгө** | **40,606.0** | **42,227.6** | **1,621.6** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 40,606.0 | 42,227.6 | 1,621.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **40,606.0** | **42,227.6** | **1,621.6** |

Дээрх хүснэгтээс харахад, үндсэн хөрөнгийн дансанд өмнөх оны үзүүлэлтээс нилээ бүхий өөрчлөлт гарсан. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нь 35,786.6 мянга болж 1,621.5 мянган төгрөгөөр өссөн нь 13,439.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, тайлант хугацаанд тооцсон хуримтлагдсан элэгдлээс тус тус шалтгаалсан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 195,744.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 70,175.8 мянган төгрөгөөр бууруулж, 125,568.8 баталсан байна. Энэ нь төсвийн төсөлд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг бууруулснаас шалтгаалсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 125,568.8 мянган төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 125,568.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 123,347.6 мянган төгрөг буюу 98.3 хувь зарцуулж, 2,361.1 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг хийсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 87,373.9 | 86,165.9 | 1,208.0 | 99% |
| 2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 12,084.4 | 11,440.9 | 643.5 | 95% |
| 3 | Хангамж, бараа материалын зардал | 7,309.2 | 7,257.2 | 52.0 | 99% |
| 4 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,980.0 | 11,979.8 | 0.2 | 100% |
| 5 | Томилолт, зочны зардал | 1,679.0 | 1,679.0 | - | 100% |
| 6 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,673.3 | 3,539.1 | 134.2 | 96% |
| 7 | Бараа үйлчилгээний бусад зардал | 616.9 | 616.9 | - | 100% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 9,649.4 мянган төгрөг, байгууллагын өөрийн үйл ажиллагааны нэмэлт орлого 5,600.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн тайланд тусгаж, хангамжийн материал 2,300.6 мянга, дотоод томилолт 4,977.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 3,360.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 1,905.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Азуре хүлэг аудит ХХК-ийн аудитор Г.Отгонбаатар, аудиторын туслах Л.Энх-Уянга нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтын менежер С.Оюунцэцэг, хоёр дахь шатны хяналтыг гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Азуре хүлэг Аудит ХХК-д 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 151,779.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,517.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 5 дугаар сараас эхлэн холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 161 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож, 10,755.5 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 5,763.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 1,137.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 1,137.7 | 2 | 1,137.7 | 100.0 |
| Зөвлөмж | 2 | 5,763.3 | 2 | 5,763.3 | 100.0 |
| **Нийт дүн** | **4** | **6,901.0** | **4** | **6,901.0** | **100.0** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх онцлог зүйл байхгүй байна.

# 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,546.3 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 438.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,108.3 мянган төгрөгийн төгрөгийн зөвлөмж өгсөн.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.2 Албан шаардлага**

Ажилчдад олгосон 3,992,750.0 төгрөгийн цалингийн урамшууллаас нийгмийн даатгал болон хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна. Худалдан авах ажиллагаанд оролцдог гэрээт ажилчдад 562,874.0 төгрөгийн хөлс төлснийг хувь хүний орлогын албан татварын тайланд шууд бус орлогоор тайлагнасан боловч нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалт "Нийгмийн даатгалд дор дурдсан ажилтан албан журмаар даатгуулна", 4.2.1-д "өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдоно гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн: Холбогдох хуулийг хэрэгжүүлэн ажиллаж зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.*

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тайлант хугацаанд 3,419,000 төгрөгийн 3 ширхэг анхан шатны баримтын иж бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд хүлээн зөвшөөрч тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь заалт "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Төсвийн хөрөнгөөр худалдан авч буй ажил үйлчилгээний төлбөр тооцоог хийхдээ хууль тогтоомжид заасан анхан шатны баримтын бүрдлийг хангаж, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах;

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 26,072,116.6 төгрөгийн 11 нэр төрлийн хөрөнгөд дахин үнэлгээ хийх, актлах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "*Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2- т "*Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна*", 6.2.1-д "*Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон*", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг журамд заасны дагуу үнэлгээг тогтоох, актлах талаар арга хэмжээ авч ажиллах;

3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

***Илрүүлэлт:*** Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 161 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож, 10,755.5 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна.

***Өгсөн зөвлөмж:***: Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дундговь аймаг дахь төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Т оо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ажилчдад олгосон 3,992,750.0 төгрөгийн цалингийн урамшууллаас нийгмийн даатгал болон хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон 958.2 мянган төгрөг байна. Худалдан авах ажиллагаанд оролцдог гэрээт ажилчдад 562,874.0 төгрөгийн хөлс төлснийг хувь хүний орлогын албан татварын тайланд шууд бус орлогоор тайлагнасан боловч нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй 135.1 мянган төгрөг байна. | 1 | 1,093.3 | | | 1 | 1,093.3 | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | **1** | **1,093.3** | | | **1** | **1,093.3** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 161 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож, 10,755.5 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна. | 1 | 10,755.5 | | | | | 1 | 10,755.5 |
| | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **10,755.5** | | | | | **1** | **10,755.5** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 3,419,000 төгрөгийн 3 ширхэг анхан шатны баримтын иж бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд хүлээн зөвшөөрч тусгасан байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 26,072,116.6 төгрөгийн 11 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **2** | **-** | | | | | **2** | **-** |
| **Нийт дүн** | **3** | **10,755.5** | | | | | **3** | **10,755.5** |

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 27 өдөр Дугаар 038 Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1,093,349.76 төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилчдад олгосон цалингийн урамшууллаас 958,260.00 төгрөгийн нийгмийн даатгал болон хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна. Худалдан авах ажиллагаанд оролцдог гэрээт ажилчдад олгосон урамшууллаас 135,089.76 төгрөгийн хувь хүний орлогын албан татварын тайланд шууд бус орлогоор тайлагнасан боловч нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дугаар зүйлийн 2 дахь заалт "Нийгмийн даатгалд дор дурдсан ажилтан албан журмаар даатгуулна", 4.2.1-д "өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т /цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдоно/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан*/Нягтлан бодох бүртгэлийн зарчим "үнэн зөв байх"/*, тус хуулийн 20.2.7-д */аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах;/* заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-т заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрүүтэй тайлагнасан Хувь хүний орлогын албан татварын тайланг холбогдох татварын байгууллагатай тооцоо нийлж, тайланг засварлан илгээж зөрчлийг арилгах;
2. Зөрүүтэй тайлагнасан Нийгмийн даатгалын тайланг холбогдох нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, тайланг засварлан илгээж зөрчлийг арилгах;

0012041784

Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 04 дүгаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Ууганбаяр), нягтлан бодогч (Э.Саранзаяа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

АЗУРЕ ХУЛУГ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР Г.ОТГОНБААТАР

---

[1] Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

**ААБ 5.3: АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫГ ҮНЭЛЖ, ШИЙДВЭРЛЭХ**

**Байгууллагын нэр: Дундговь аймгийн Орон нутгийн эмчийн газар**
**Тайлант хугацаа: 2022/12/31**

| № | АГАДҮТ | АГАДҮТ-ын дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Шалгуур үзүүлэлт | | Асуудлыг шийдвэрлэсэн байдал | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | Аудитын багийн санал | Аудитыг хянан удирдах ажилтнуудын санал | |
| | | | | | | | | | Батлах I түвшний санал | Батлах II түвшний санал |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Мөнгөн хөрөнгө | Харилцах данс | 3,419,000 төгрөгийн 3 ширхэг анхан шатны баримтын иж бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд хүлээн зөвшөөрч тусгасан байна. | 3,419,000.00 | Тийм | УСНББОУС 2 "Мөнгөн гүйлгээ" | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь заалт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | Зөвлөмж | Зөвлөмж | Зөвлөмж |
| 3 | Үндсэн хөрөнгө | Үндсэн хөрөнгө | Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөгүй 26,072,116.6 төгрөгийн 11 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна. Эдгээрийг акталж устгах, дахин үнэлэхээр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээгүй байна. | - | Тийм | УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө" | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй болович гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2- т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна. | Зөвлөмж | Зөвлөмж | Зөвлөмж |
| 5 | Цалингийн зардал | цалин урамшуулал | Ажилчдад олгосон 3,992,750.0 төгрөгийн цалингийн урамшууллаас нийгмийн даатгал болон хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна. | 958,260.00 | Үгүй | УСНББОУС 2 "Мөнгөн гүйлгээ" | Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалт "Нийгмийн даатгалд дор дурьдсан ажилтан албан журмаар даатгуулна", 4.2.1-д "өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна | Албан шаардлага | Албан шаардлага | Албан шаардлага |
| 6 | Урсгал зардал | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | Худалдан авах ажиллагаанд оролцдог гэрээт ажилчдад 562,874.0 төгрөгийн хөлс төлсөнийг хувь хүний орлогын албан татварын тайланд шууд бус орлогоор тайлагнасан боловч нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй байна. | 135,089.76 | Үгүй | УСНББОУС 2 "Мөнгөн гүйлгээ" | Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалт "Нийгмийн даатгалд дор дурьдсан ажилтан албан журмаар даатгуулна", 4.2.1-д "өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлалтийн орлогод албан татвар ногдоно гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна. | Албан шаардлага | Албан шаардлага | Албан шаардлага |
| 7 | Шилэн дансны тухай хууль | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | Шилэн дансны цахим сайтад 6 мэдээлэл хугацаа хоцроож, орлогын 10,775,500.0 төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй байна. | | Тийм | | Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4-т "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" | Зөвлөмж | Зөвлөмж | Зөвлөмж |
| | | | | 4,512,349.8 | | | | | | |

Бэлтгэсэн : Г.Отгонбаяр Огноо :

Анхан шатанд хянасан : Г.[illegible] Огноо :

Хоёр дахь шатанд хянасан
Аудитын менежер : [illegible].Наранцацрал Огноо :

Дарга. Тэргүүлэх аудитор : Р.Мөнхтогтох Огноо :

Танилцаж зөвшөөрсөн:

Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Адъяасүрэн Огноо :

Нягтлан бодогч Э.Саранзаяа Огноо :

ТБАГҮТҮГ
4816121143 ⑩ 3431274